**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 23 өдөр Дугаар А/70 Хатан суудал

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.4.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах” 2016 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 11/2016 дугаар гэрээний 3.4 дэх заалтыг үндэслэн хуучин Эрүүл мэндийн төвийн 428$м^2$ талбайтай барилгын доорх 1196$м^2$ газрыг дуудлага худалдаагаар худалдаж авсан иргэн Бэхтулга овогтой Анхбаярт (ВВ83022812) хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших эрхийн гэрээ байгуулж, гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Д.Жаргалмаа)-д даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу эзэмшиж газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч Б.Анхбаярт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

D:\D\албан бичиг\Zahiramj\Газар эзэмших эрх шилжүүлэх тухай.docx

642301099

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны
өдрийн А/70 дугаар захирамжийн хавсралт

# ГАЗАР ЭЗЭМШИГЧ ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Ургийн овог | Эцэг, эхийн нэр | Өөрийн нэр | Регистрийн зураг | Газар эзэмших, ашиглах эрхийн төрөл | Газрын хэмжээ /м.кв-аар/ | Байршил, хаяг | Газар ашиглалтын зориулалт | Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Умбагай | Бэхтулга | Анхбаяр | ВВ73021812 | Эзэмших | 1196 | Баянлиг сум, Хатансуудал 5 дугаар баг, Жаргалант 1-123 тоот | 2105: Эрүүл мэндийн байгууллага | 15 |

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 26 өдөр Дугаар А/71 Хатан суудал

ЭХО аппарат хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгж ,түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ,ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд ЭХО аппарат хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай .

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энхбат – Засаг даргын орлогч

Гишүүд: Д.Нансалмаа – Эрүүл мэндийн төвийн дарга

Ш.Хоролсүрэн – Санхүү албаны дарга

А.Цэнгэл – Эрүүл мэндийн төвийн нярав

Н.Мөнхгэрэл – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2.Барааг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу хүлээн авч Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч болон гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301101

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 26 өдөр Дугаар А/72 Хатан суудал

Малын хагас жилийн түүвэр судалгаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.в, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/276 дугаар захирамж зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд 2023 оны хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөс 6 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулан явуулсугай.

2.Малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэлд тулгуурлан сумын түвшний нэгтгэл гарч түүнд үндэслэн нөхөн төлбөр олгогддог тул мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг хангаж мэдээллийг шивэх явцад гарч болзошгүй алдаа, нөхөн төлбөр олгох явцад гарах маргаан зэргээс урьдчилан сэргийлж, судалгаад сонгогдсон өрх нэг бүрийг цахим программын дагуу шивж, тооллогын ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Малын түүвэр судалгааны ажлыг аргачлал, маягт зааврыг бүрэн хангаж, түүвэр судалгааны нэгтгэлийг аймгийн Статистикийн хэлтэст 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн дотор хүргүүлэхийг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Ж.Оюунтунгалагт) - т үүрэг болгосугай.

5.Малын түүвэр судалгааны ажлын бэлтгэлийг хангуулан зохих журмын дагуу ямар нэгэн зөрчил гаргахгүйгээр зохион байгуулан, хяналт шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат) - д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

D:\D\албан бичиг\Zahiramj\мал тооллого явуулах тухай.docx

6/2301103

Сумын Засаг даргын 2023 оны 05.
дугаар сарын 26. –ны өдрийн А/129 дугаар
захирамжийн хавсралт

**МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ**
**КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга:

Ж.Энхбат – Засаг даргын орлогч

Гишүүд:

Ж.Оюунтунгалаг – Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Д.Батаа – 1 дүгээр багийн Засаг дарга

Ц.Намхайхорол – 2 дугаар багийн Засаг дарга

С.Ганхүлэг – 3 дугаар багийн Засаг дарга

С.Баттулга – 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Амаржаргал – 5 дугаар багийн Засаг дарга

________________oOo________________

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр | Дугаар А/73 | Хатан суудал

Соёлын төвийн эрхлэгч Адъяагийн Цэндмаад
ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвийн эрхлэгч Адъяагийн Цэндмаад ур чадварын нэмэгдэл олгосугай.

2.Соёлын төвийн эрхлэгч Адъяагийн Цэндмаад ур чадварын нэмэгдлийг 25%-иар тооцон 5 дугаар сард бодож олгохыг Нягтлан бодогч (Г.Тунгалаг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА О.МӨНХБАТ

642301105

D:\D\албан бичиг\Zahiramj\Ур чадварын нэмэгдэл олгох.docx

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр                    Дугаар А/74                    Хатан суудал

Судалгааны ажлыг шуурхай зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай" А/88 дугаар тушаал, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/16-А/04 дүгээр хамтарсан тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн "Судалгааны ажлыг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулах тухай" А/266 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал"-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энхбат - Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Амарбаяр - Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: С.Ганхүлэг - 3 дугаар багийн Засаг дарга
С.Баттулга - 4 дүгээр багийн Засаг дарга
Б.Амаржаргал - 5 дугаар багийн Засаг дарга

2.Багуудад мэдээлэл цуглуулах тоологчдод газарчлах, судалгаанд хамруулах өрхүүдэд саадгүй очих ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

642301107

D:\D\албан бичиг\Zahiramj\Ажлын хэсэг байгуулах тухай.docx

3.Судалгааны ажлыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор чанартай, хариуцлагатай зохион байгуулж дуусгахыг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/75 Хатан суудал

Хатан суудал 5 дугаар багт 0.4кВ-ийн ЦДАШ-ын өргөтгөлийн ажил хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгж ,түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх Хатан суудал 5 дугаар багт 0.4кВ-ийн ЦДАШ-ын өргөтгөлийн ажил хийх үйл явц , гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авах ажлын хэсгийн доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч : Ж.Энхбат -Засаг даргын орлогч

Гишүүд : Ж.Оюунтунгалаг-Төсөв төрийн сангийн мэргэжилтэн
Д.Жаргалмаа -Газрын даамал
Б.Адъяанасан -Эрчим хүчний мэргэжилтэн
Ц.Цэндцэвээн-Цахилгаанчин

2.Ажлыг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301113

D:\D\албан бичиг\Zahiramj\Ажлын хэсэг байгуулах тухай.docx

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр | Дугаар А/76 | Хатан суудал

Хичээлийн байр болон дотуур байрыг камержуулж хүчин
чадлыг нэмэгдүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх Хичээлийн байр болон дотуур байрыг камержуулж хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын үйл явц, гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авах ажлын хэсгийн доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай .

Ажлын хэсгийн ахлагч : Г.Мөнхсүх (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: С.Цэдэндорж (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Б.Нарангэрэл (Нягтлан бодогч)
Л.Отгонсүрэн (Хэсгийн төлөөлөгч)

2.Ажлыг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301115

D:\D\албан бичиг\Zahiramj\Ажлын хэсэг байгуулах тухай.docx

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
# ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/77 Хатан суудал

Шуурхай штаб шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах бүх шатны бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллах Шуурхай штабын шинэчилсэн бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

2.Гамшгаас хамгаалах бүх шатны бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Шуурхай штабын бэлэн байдлыг хангаж үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллахыг Шуурхай штабын дарга, Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/09 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301117

D:\D\албан бичиг\Zahiramj\Шуурхай штаб байгуулах тухай.docx

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 05.-ны өдрийн А/77 дугээр
захирамжийн хавсралт

**СУМЫН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН**

| | |
|---|---|
| Шуурхай штабын дарга: | Ж.Энхбат (Засаг даргын орлогч) |
| Нарийн бичгийн дарга: | Д.Тогмид (Архив, бичиг хэргийн эрхлэгч) |
| Гишүүд: | Г.Мөнхсүх (Засаг даргын Тамгын газрын дарга) |
| | С.Цэдэндорж (Ерөнхий боловсролын сургуулийн захирал) |
| | А.Мөнхзул (Цэцэрлэгийн эрхлэгч) |
| | А.Цэндмаа (Соёлын төвийн эрхлэгч) |
| | Д.Нансалмаа (Эрүүл мэндийн төвийн дарга) |
| | Х.Аскарбек (ЗХ-ний 103 дугаар тусгай салбарын захирагч) |
| | Н.Цэрэндолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга) |
| | А.Гантулга (ХЖДҮХ асуудал хариуцсан мэргэжилтэн) |
| | Л.Отгонсүрэн (Хэсгийн төлөөлөгч) |

................o0o................

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/78 Хатан суудал

Сумын орон тооны бус мэргэжлийн
анги байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан дүрмийн 1.3, 1.9, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон тооны бус мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулсугай.

2.Сумын орон тооны бус мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулж, дадлага сургуулилт хийлгэж байхыг Мэргэжлийн ангийн дарга (Ж.Энхбат)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/117 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301119

D:\D\албан бичиг\Zahiramj\Шуурхай штаб байгуулах тухай.docx

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 05-ны өдрийн А/78 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**МЭРГЭЖЛИЙН АНГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН**

Сумын онцгой комиссын дарга: О.Мөнхбат (Засаг дарга)

Сумын онцгой комиссын нарийн бичгийн дарга: Г.Мөнхсүх (ЗДТГ-ын дарга)

Мэргэжлийн ангийн дарга: Ж.Энхбат (Засаг даргын орлогч)

Хангалт хариуцсан ажилтан: Ш.Хоролсүрэн (Санхүү албаны дарга)

Аюулгүй байдал хариуцсан ажилтан: А.Цэндмаа (Соёлын төвийн эрхлэгч)

Хэв журам хариуцсан ажилтан: Л.Пүрэвсүрэн (Хэсгийн цагдаа)

Хөдөө аж ахуй хариуцсан ажилтан: Ж.Оюунтунгалаг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Эмнэлэг үйлчилгээ хариуцсан ажилтан: Д.Нансалмаа (ЭМТ-ийн дарга)

Сургуулийн захирал: С.Цэдэндорж

Цэцэрлэгийн эрхлэгч: А.Мөнхзул

Цаг уурын мэдээлэл хариуцсан ажилтан: Х.Бямбажаргал (Цаг уурч)

Баримт бичиг хариуцсан ажилтан: Д.Тогмид (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Мэдээлэл сурталчилгааны алба: Б.Дэлгэрмаа (Үйлчилгээний оператор, хүний нөөцийн ажилтан)

Механикжуулсан хэсгийн дарга: А.Гантулга (Байгаль хамгаалагч)

Аврах бүлгийн дарга: Б.Амарбаяр (Халамжийн мэргэжилтэн) ,

Нийгмийн хамгааллын бүлэг: Х.Баасандорж (Сургуулийн нийгмийн ажилтан)

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 05 ны өдрийн А/48 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

# ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Мэргэжлийн анги удирдах бүрэлдэхүүн**

Мэргэжлийн ангийн дарга: Ж.Энхбат (Засаг даргын орлогч)

**Гал түймэр унтраах бүлэг**

Бүлгийн дарга:Б.Амарбаяр (ХЭХАХ мэргэжилтэн)

Жолооч: П.Норовсамбуу (Нярав)

Аврагч:Г.Баасанбат (Технологийн багш)

Аврагч:Г.Бат-Очир (Биологийн багш)

Аврагч:Б.Ууганбаатар (Сургуулийн нярав)

Аврагч:С.Мөнхбаатар (Цэцэрлэгийн жижүүр)

Аврагч А.Цэнгэл (ЭМТ-ийн нярав)

Аврагч: Д.Батаа (1 дүгээр багийн Засаг дарга)

**Эрэн хайх, аврах бүлэг**

Бүлгийн дарга:Б.Амаржаргал (5 дугаар багийн Засаг дарга)

Аврагч: Н.Тогтохбаяр (Сургуулийн жижүүр)

Аврагч: Ш.Мэндсайхан (Мэдээлэлзүйн багш)

Аврагч: П.Нэргүй (Сургуулийн жижүүр)

Аврагч: Б.Гантулга (Биеийн тамирын багш)

Аврагч: Б.Зэмбэ (Цэцэрлэгийн багш)

**Механикжуулсан хэсэг**

Хэсгийн ахлагч: А.Гантулга (Байгаль хамгаалагч)

Жолооч:А.Цэнд-Очир (Тамгын газрын жолооч)

Цахилгаанчин:Ц.Цэндцэвээн (Тамгын газрын цахилгаанчин)

Жолооч:Б.Энхбат (Сургуулийн цахилгаанчин)

Сантехник: Г.Хүрэлбаатар (Сургуулийн жижүүр)

Уурын зуухны галч: Р.Нэргүй

Гагнуурчин: С.Амарсанаа (Эрчим хүчний ажилтан)

Гишүүн: Ц.Намхайхорол (2 дугаар багийн Засаг дарга)

**Эмнэлгийн бүлэг**

Бүлгийн ахлагч: Г.Эрдэнэчимэг (Эрүүл мэндийн төвийн статистикч)

Их эмч: Б.Чулуунтогтох (Хүүхдийн эмч) .

Сувилагч: Б.Эрдэнэцэцэг (Нийгмийн эрүүл мэндийн ажилтан)

Сувилагч: Б.Сумъяасүрэн (Эрүүл мэндийн төвийн сувилагч)

Асрагч: Л.Бат-Ууган (Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч)

Асрагч:П.Дашдулам (Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч)

**Хэв журам сахиулах бүлэг**

Бүлгийн ахлагч: Л.Отгонсүрэн (Хэсгийн төлөөлөгч)

Идэвхтэн: Л.Пүрэвсүрэн (Хэсгийн цагдаа)

Идэвхтэн: С.Баттулга (4 дүгээр багийн Засаг дарга)

Идэвхтэн:Б.Энхтуяа (Сургуулийн англи хэлний багш)

Идэвхтэн:Б.Рэнцэндулам (Сургуулийн бага ангийн багш)

**Анхны тусламжийн бүлэг**

Бүлгийн дарга: Г.Энхбаяр (Их эмч)

Жолооч:Б.Ганбаатар (Эрүүл мэндийн төвийн жолооч)

Идэвхтэн: Ш.Гантулга: (Их эмч)

Идэвхтэн: Г.Батзориг (Биологийн багш)

Идэвхтэн:Б.Цэнгэлмаа (Багийн эмч)

Идэвхтэн:Н.Цолмон (Лаборант)

Идэвхтэн: Г.Зоригт (Эх баригч)

Идэвхтэн: Х.Нарантогтох (Ахлах сувилагч)

Идэвхтэн: С.Лхам-Осоржин (Сувилагч)

**Хөдөө аж ахуйн бүлэг**

Бүлгийн дарга: Н.Цэрэндолгор (Мал эмнэлэгийн улсын байцаагч,тасгийн дарга)

Гишүүд Б.Болор-Эрдэнэ (Малын эмч)

Гишүүд :А.Элдэв-Очир (Тархвар зүйч)

Гишүүд:Д.Магнайбаяр (Малын эмч)

Гишүүд: С.Ганхүлэг (3 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Ерөөлт (Малын эмч)

**Холбоо зарлан мэдээллийн бүлэг**

Бүлгийн ахлагч: М.Төмөртогоо (Соёлын төвийн багш)

Холбоочин: Н.Мөнхцэцэг (Дуу хөгжмийн багш)

Холбоочин: Ж.Лхагва (Нийгмийн даатгалын улсын байцаагч)

Холбоочин: С.Болор-Эрдэнэ (Иргэний бүртгэлийн ажилтан)

Холбоочин:Х.Бямбажаргал (Цаг уурч)

**Сургалт мэдээллийн алба**

Бүлгийн ахлагч: Б.Дэлгэрмаа (Үйлчилгээний оператор, хүний нөөцийн ажилтан)

Гишүүн: М.Нямжаргал (Бага ангийн багш)

Гишүүн: Г.Энхжаргал (Түүх нийгмийн багш)

Гишүүн: С.Дашцэрэн (Сургуулийн номын санч)

Гишүүн: Б.Даваацэрэн (Газарзүйн багш)

**Хангалтын алба**

Бүлгийн ахлагч: С.Мөнхцэцэг (Нягтлан бодогч)

Гишүүн: Б.Бадамсүрэн

Гишүүн: Ч.Лувсандулам (ЗДТГ-н үйлчлэгч)

Гишүүн: Г.Тогоотогтох (Цэцэрлэгийн нярав)

Гишүүн: Ш.Шинэхүү (Цэцэрлэгийн жижүүр)

Гишүүн: Р.Соёл-Эрдэнэ (Бага ангийн багш)

**Нийгмийн хамгааллын бүлэг** ,

Бүлгийн ахлагч: Х.Баасандорж (Сургуулийн нийгмийн ажилтан)

Гишүүн: Н.Мөнхгэрэл (Нийгмийн бодлогын мэргэжилтний үүрэг гүйцэтгэгч)

Гишүүн: Д.Тогмид (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

-------------------oOo-----------------

Сургуулийн

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/79 Хатан суудал

Ослын үеийн нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 59.1.23, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн онцгой комиссын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 30 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг ослын үеийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд шилжүүлсүгэй.

2.Ослын үеийн нэгдсэн тогтолцоонд үүрэг гүйцэтгэх томилгоот бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

3.Дадлага сургуулилтад хариуцлагатай оролцохыг томилгоот бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301121

Сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар
сарын 05-ны өдрийн А/19 дугаар
захирамжийн хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 05 өдөр Дугаар А/80 Хатан суудал

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2023 оны “Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” 105 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 сарын 15-ны өдрийн 10/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөхөөр хүсэлт гаргасан 1 иргэний 620м2 газрыг нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлж, хавсралтаар батлалсугай.

2.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх үүргээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж ажиллахыг газрын даамал (Д.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.

3.Газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

D:\D\албан бичиг\Zahiramj\Газар эзэмших эрх шилжүүлэх тухай.docx

0422301123

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 05
өдрийн А/80 дугаар захирамжийн хавсралт

## ГАЗАР ӨМЧЛӨХ ХҮСЭЛТ ГАРГАСАН ИРГЭДИЙН НЭРС

| Д/Д | Өмчлөгчийн | | | | Газрын | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг эхийн нэр | Нэр | Регистрийн дугаар | Талбайн хэмжээ /м2/ | Байршил, хаяг | Газрын үнэ | Зориулалт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Парз | Мөнх-Очир | Энхжаргал | ВВ81021109 | 620 | Хатансуудал 5-р баг, Уранхайрхан 6-р гудамж 648в | 347200 | Гэр, орон сууцны хашааны газар |

........................................о0о..........................................

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 07 өдөр Дугаар А/81 Хатан суудал

Газар өвлүүлэн эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Өвлөх эрхийн гэрчилгээ”-ний дагуу хавсралтад тусгагдсан 1 иргэнд өвөлжөө, хаваржааны зориулалттай газар эзэмших эрхийг 11 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших эрхийн гэрээ байгуулж, гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Д.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

D:\D\албан бичиг\Zahiramj\Газар эзэмших эрх шилжүүлэх тухай.docx

642301127

Сумын Засаг даргын 2023 оны ..06.. дугаар сарын
..07..-ны өдрийн ..А/81.. дугаар захирамжийн хавсралт

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦААГ СУНГАХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

| Д/Д | Эзэмшигчийн | | | | Газрын | | | | Эзэмших хугацаа /жил/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ургийн овог | Эцэг эхийн нэр | Нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Талбайн хэмжээ /м2/ | Байршил, хаяг | Газрын зориулалт | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Боржигон | Шуушаа | Чинзориг | СЙ71072818 | 6401001791 | 700 | Бага баян 3-р баг, "Хар цохио" | Хаваржаа | 15 |

____________________oOo____________________

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 07 өдөр Дугаар А/82 Хатан суудал

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 1 иргэний газар эзэмших эрхийг 15 жилийн хугацаатай сунгаж, хавсралтад заасны дагуу эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх үүсэж байгаа газрыг улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ олгож, гэрээ байгуулахыг Газрын даамал (Д.Жаргалмаа)-д, газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу эзэмшин газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА О.МӨНХБАТ

D:\D\албан бичиг\Zahiramj\Газар эзэмших эрх шилжүүлэх тухай.docx

6423011 9

Сумын Засаг даргын 2023 оны ..06.. дугаар сарын
..05..-ны өдрийн А/82 дугаар захирамжийн хавсралт

# ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦААГ СУНГАХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

| Д/Д | Эзэмшигчийн | | | | Газрын | | | | Эзэмших хугацаа /жил/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ургийн овог | Эцэг эхийн нэр | Нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Талбайн хэмжээ /м2/ | Байршил, хаяг | Газрын зориулалт | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Боржигон | Шуушаа | Чинзориг | СЙ71072818 | 6401001791 | 700 | Бага баян 3-р баг, "Хар цохио" | Хаваржаа | 15 |

______________________oOo__________________________

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/83 Хатан суудал

Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.11.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатансуудал 5 дугаар багийн нутагт байрлах "Баян-Аараг" хүнсний дэлгүүрт тамхи худалдаалах зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг "Баян-Аараг" дэлгүүрийн эзэн (Ч.Соном-Иш)-д үүрэг болгосугай.

3.Худалдаа үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомж, цагийн хуваарийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Л.Отгонсүрэн)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжинд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301131

D:\D\албан бичиг\Zahiramj\Зөвшөөрөл олгох тухай.docx

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/84 Хатан суудал

Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.11.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатансуудал 5 дугаар багийн нутагт байрлах "Лигийн гол-1" хүнсний дэлгүүрт тамхи худалдаалах зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг "Лигийн гол-1" дэлгүүрийн эзэн (Д.Батсүх)-д үүрэг болгосугай.

3.Худалдаа үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомж, цагийн хуваарийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Л.Отгонсүрэн)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжинд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301133

D:\D\албан бичиг\Zahiramj\Зөвшөөрөл олгох тухай.docx

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/35 Хатан суудал

Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.11.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатансуудал 5 дугаар багийн нутагт байрлах "Оргилсайхан" хүнсний дэлгүүрт тамхи худалдаалах зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг "Оргилсайхан" дэлгүүрийн эзэн (Д.Баатарсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Худалдаа үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомж, цагийн хуваарийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Л.Отгонсүрэн)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжинд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301135

D:\D\албан бичиг\Zahiramj\Зөвшөөрөл олгох тухай.docx

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/86 Хатан суудал

Соёлын төвийн тохижилтын ажлыг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Соёлын төвийн тохижилтын ажлын” гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Мөнхсүх - Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: А.Цэндмаа - Соёлын төвийн дарга

С.Болор-Эрдэнэ - Улсын бүртгэгч

Н.Мөнхгэрэл-Нийгмийн бодлогын мэргэжилтэн

С.Бадамсүрэн - Нягтлан бодогч

2.“Соёлын төвийн тохижилтын ажлыг” захиалагчтай байгуулсан гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Мөнхсүх)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301137

D:\D\албан бичиг\Zahiramj\Ажлын хэсэг байгуулах тухай.docx

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 20 өдөр | Дугаар А/87 | Хатан суудал

Малжуулах арга хэмжээг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулахтухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1,Баянхонгор аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” 485 дугаар тоот албан бичиг, Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн“ Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг арга хэмжээ” 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг арга хэмжээ”-д хамрагдах хүсэлтэй малчин өрхийг сонгон шалгаруулж, материалыг бүрдүүлж Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлэх.

2.Малчин өрхийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Амарбаяр (Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Оюунтунгалаг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Н.Цэрэндолгор (Хөдөө аж ахуй тасгийн дарга )

3.Малжуулах хөтөлбөрт хамрагдах өрхийг сонгон шалгаруулж, тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Амарбаяр)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА О.МӨНХБАТ

642301141

D:\D\албан бичиг\Zahiramj\Ажлын хэсэг байгуулах тухай.docx